



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/417

Есөнбулаг

Захирамжид өөрчлөлт оруулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хурлын 2023 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 29 дүгээр хурлын шийдвэрийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/417 дугаар захирамжийн хавсралтаас 1, 2, 13, 21, 22 дугаар байртай холбогдох төсөл, арга хэмжээний хэсгийг хассугай.

2. Дээрх хассан төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг Төрийн сан дахь орон нутгийн хөгжлийн сангийн 100050052400 тоот дансанд буцааж төвлөрүүлэхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ